# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
# 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Чойр хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 5 | 2023 онд хүрэх Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хагас жилээр | | |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| *"Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1.1.1 | Нийгмийн даатгалын тухай хуульд орсон өөрчлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, дээд газраас ирүүлсэн холбогдох журам, дүрэм, заавар зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах | - | Хэрэгжилтийг зохион байгуулсан журам, дүрэм заавар,зөвлөмжийн тоо | 2023 онд хэрэгжилтийг зохион байгуулсан журам, дүрэм, заавар, зөвлөмжийн тоо | Хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах, үр дүнг тооцсон байна. | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаар сургалтыг 25 ажил олгогчид хийж, 315 албан хаагч хамруулсан байна.<br>НДЕГ-ын даргын 02 албан даалгаврын дагуу ажлын байрны цаг ашиглалт, бүтээмж, эмх цэгцийг сайжруулахаар ажилтан албан хаагч нарт 2 удаа сургалт явуулж 13 ажилтан хамрагдлаа. НДЕГ-ын даргын 01 тушаалын дагуу аймгийн Татварын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нийцүүлэн гарч байгаа 48 дүрэм, журам, заавруud бүрэн хэрэгжиж байна. 100%** | 100 |
| 1.1.2. | Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, сангийн орлогын бааз суурийг өргөжүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуй нэгж, байгууллага, даатгуулагчдыг шинээр хамруулах ажлыг зохион байгуулах | 10000,0 | -Хамрагдах нийгмийн даатгалын шимтгэл төлөгч байгууллагын тоо<br><br>-Хамрагдах даатгуулагчийн тоо | -9 байгууллага<br>-19 даатгуулагч | аж ахуй нэгж байгууллагын тоо -5<br>Даатгуулагчийн тоо-20 | Хамрагдалтыг өсгөх, сангийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд байгууллагын сан хариуцсан мэргэжилтэнг ХАМРАГДАЛТ-н 3 хоногийн сургалтанд хамруулж, байгууллагын албан ёсны пэйж хуудсанд нөлөөллийн контент постуудыг оруулж ажилласан. Мөн аймгийн ХХАА-н газартай хамтран жижиг дунд үйлдвэрлэлийн төсөлд хамрагдсан иргэдэд НД тухай хуулийн талаар сургалт мэдээлэл өгч ажилласны дүнд<br>6 ААНБ-н 19 албан журмын даатгуулагч шинээр хамрагдсан байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийг нийгмийн даатгалд хамруулахыг халамж үйлчилгээний газрын удирдлагууд болон хариуцсан мэргэжилтэнүүдтэй хамтран ажиллаж байна.<br><br>**Хүрсэн түвшин: Шинээр 5 байгууллага хамруулахаас 6 байгууллага хамруулсан. 20 даатгуулагч хамруулахаас эхний 5 сарын байдлаар 19 албан журмын даатгуулагчийг хамруулсан байна. 95%** | |
| 1.1.3 | Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагчдын тоог 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх, малчдын нийгмийн даатгалын хамагдалтыг 30 хувиар нэмэгдүүлэх | - | Шинээр хамрагдсан СДД тоо 10-с доошгүй хувиар Малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг 30 хувиар нэмэгдүүлсэн байна. | 2023 онд шинээр 45 иргэнийг СДД хамруулсан. Нийт СДД тоо 685<br>-Малчин-18<br>-0-3 насны хүүхдээ асарч байгаа эхийн тоо-226<br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эцэг, эхийг тоо-0 | Шинээр хамруулсан СДД-н тоо-100<br>Малчдын тоо-45<br>-0-3 насны хүүхдээ асарч байгаа эхийн тоо-27<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эцэг, эхийг тоо-40 | Ажил олгогчийн хамрагдалт 6 ААНБ -16 даатгуулагч,<br><br>Нийт 2630 иргэний тэтгэврийг сард 263 сая төгрөгөөр нэмэгдүүлэн олгосон.<br>2024 оныг Нийгмийн даатгалын хамралтын жил болгон зарласантай холбоотой нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх 3 хоногийн сургалтад Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнг сургаж, багийн дарга нартай хамтран ажиллаж байна. Үр дүн нь жилийн эцсээр гарна.<br>2024 оны 01 дүгээр сарын 01-нээс Сайн дурын даатгуулагч малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төрөөс хариуцан төлнө. 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эхийн сайн дурын даатгалын шимтгэлийг 100 хувь хариуцан төлнө гэсэн заалтууд хуульд шинээр нэмэгдсэн. Дээрх хуулийн хүрээнд сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн тоо:100-100%<br>Сайн дурын даатгуулагч Малчин-45-100%<br>0-3 настай хүүхдээ харж байгаа эх-30-100%<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эцэг, эхийг тоо-25-62%<br><br>**Хүрсэн түвшни: 90.5%** | 90 |
| **Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| *“Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1.1. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх. | - | -Батлагдсан 21,684,92 сая төгрөгийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, | - Нийгмийн даатгалын орлогын төлөвлөгөө 21,684,92 | нийгмийн даатгалын сангийн орлогыг 5,586,4 сая төгрөгөөр биелүүлсэн байх. | Сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хуримтлагдсан авлагыг барагдуулахаар аж ахуй нэгж байгууллагуудтай шимтгэлийг барагдуулах гэрээ байгуулан ажиллах, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилан таниулах, аж ахуй нэгж байгууллагуудад албан шаардлага хүргүүлж шимтгэл төлөгч байгууллагаар бүртгэх зэргээр ажлуудыг зохион байгуулан ажилласны үр дүнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өсөнөөр жигд биелүүлэн ажиллана. | | | сангийн орлого 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 9042829.3 мянган төгрөгт хүрч орлогын төлөвлөгөө биелэсэн.<br><br>**Хүрсэн түвшин: 7,887.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл орлого оруулахаас 9,042.8 сая төгрөгийн орлого орж орлогын төлөвлөгөө 115.2% биелсэн байна.** | |
| 2.1.2. | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах талаар нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж оны эхний үлдэгдлээс бууруулах | - | Ажил олгогчийн шимтгэлийн авлагыг 10 хувь бууруулсан. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 2023 оны жилийн эцсийн байдлаар 8,184,236 сая төгрөг байна. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдэлээс 10 хувиас доошгүй хэмжээгээр бууруулсан байх | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/62 дугаартай тушаалын дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>2023 онд үүссэн шимтгэлийн авлагын 95 хувийг Шивээ-Овоо ХК дангаараа /7,300,612 сая/ эзлэж байна.<br>5 байгууллагын 20 сая төгрөгийг барагдуулахаар иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.<br>Өмнөх оны 8,184,236 сая төгрөгний авлагаас<br>Авлага барагдуулах ажлын хүрээнд 160 сая төгрөгийн авлагыг дээрх ажлын хүрээнд барагдуулан ажиллаа. Үүнд: Шивээ-Овоо ХК 100 сая, Говь чанар 23 сая, Илчит сансар 13 сая гэх мэт<br><br>**Хүрсэн түвшин: Оны эхний авлага 160 сая төгрөгөөр буурсан байна. Нийт авлагын 2,7%-ийг буурсан байна.** | 75 |
| 2.1.3 | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | - | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээг тогтоосон хугацаанд үзүүлсэн байна. | Нийгмийн даатгалын сангийн 15652320,0 мянган төгрөгийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу 5469 иргэнд зарцуулсан. | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох | Нийт батлагдсан төсөв 10054816.2 мянган төгрөг. Үүнээс 8912677.7 мянган төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг 6410 иргэнд тогтоох, шилжүүлэх байдлаар зарцуулсан. Батлагдсан төсвийг хэтрүүлээгүй болно.<br><br>**Хүрсэн түвшин: Батлагдсан төсөв хэтрүүлэн зарцуулаагүй. 100%** | 100 |
| | Үйл ажиллагааны батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | 10000,0 | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулаагүй байна. | Батлагдсан 303,8 сая төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулсан | а) Батлагдсан 606.042.4 төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>б) Ажиллагсадтай холбоотой цалин, | Байгууллагын хагас жилийн батлагдсан төсөв 303021.2 мянган төгрөг. Зардлын ангиллын дагуу зарцуулж байгаа. Хагас жилийн байдлаар ажиллагсадтай холбоотой өр авлага үүсээгүй байна.<br><br>**Хүрсэн түвшин: Батлагдсан төсөв хэтрүүлэн зарцуулаагүй. 100%** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.4 | | | Ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажилласан байна. Улсын Их хурлын 2016 оны 47 дугаар тогтоол, төсвийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, орон too, хөрөнгө бэлтгэх, шатахуун болон урсгал засварын зардал зэрэг төсвийн хэмнэлтийн хүрээнд боломжтой арга хэмжээг авсан байна. | | шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгэхгүй байх. | | 100 |
| 2.1.5 | “Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх | - | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн төслийн багаас хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн төслийн багаас зохион байгуулсан ажилд оролцоно. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “core”системээр хөтлөх гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс Улсын хэмжээнд нэвтэрч байгаа “core”системд нягтлан бодох бүртгэлийн анхан шатны ажлуудыг ээлж дараалалтай хэрэгжүүлэн ажиллаж байна. Манай аймгийн хэмжээнд хүндрэл асуудал тулгарсан зүйлгүй. Хагас жилийн нийгмийн даатгалын сангийн тайланг энэ системээр гаргахаар зорин ажиллаж байна. Энэ систем бүрэн хэрэгжиж эхэлснээр нягтлан бодох бүртгэл мөн даатгалын үйлчилгээ бүрэн цахимжих боломж бүрдэнэ.<br><br>**Хүрсэн түвшин: Үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэл бүрэн, сангийн нягтлан бодох бүртгэл шат дараалалтайгаар “core”системд шилжиж байна. Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны тайланг “core”системээр тайлагнахаар ажиллаж байна.** | 100 |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| *“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг | | Шилэн дансанд мэдээ | -100%<br>-98,5% | -100%<br>-100% | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2024 оны хагас жилийн байдлаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1. | хангаж, мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв байршуулах.<br>Мэдээллийн бүрдлийг хангах. | | оруулалтын хувь<br><br>Хугацаанд нь оруулсан мэдээний хувь | 316 мэдээ хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлсэн | | байгууллагын үйл ажиллагаа болон сангийн мэдээлэлд засвар орсон болон хугацаа хэтэрсэн төлөв байхгүй байна. Мэдээллийг хуулийн хугацаанд оруулж мэдээлсэн байна.<br>**Хүрсэн түвшин: Хэрэгжилт 100%** | |
| 3.1.2. | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2 дугаар хэсэгт тусгасан “Гамшгаас хамгаалах, эрсдлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг төрийн байгууллага тухай жилийн төсвийнхөө 1,0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухай жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлыг 15 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцжжлах” тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | - | Нийгмийн даатгалын газрын 205 оны үйл ажиллагааны төсвийн төслийг боловсруулахдаа 1,0 хувийн эрсдэлийн хөрөнгийг тусгах | 2024 оны төсвийн төлөвлөгөөнд зардлыг тусгасан боловч батлагдаагүй | Шаардлагатай төсөв хөрөнгийн тооцог гаргаж хуулийн хугацаанд дээд байгууллагад хүргүүлсэн байна. | 2025 оны үйл ажиллагааны төсвийн төсөөлөлд 1500,000 төгрөгийг батлуулахаар хуулийн хугацаанд дээд газар хүргүүлж ажиллана.<br><br>Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг гарган батлуулахаар Аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэн ажиллаа.<br><br>**Хүрсэн түвшин: 100%** | 100 |
| 3.1.3 | Байгууллагын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийлгэж эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Нийгмийн даатгалын газрын 2025 оны үйл ажиллагааны төсвийн төсөөллийг боловсруулахдаа 1,0 хувийн эрсдэлийн хөрөнгийг тусгах | 2024 оны төсвийн төлөвлөгөөнд зардлыг тусгасан боловч батлагдаагүй | Шаардлагатай төсөв хөрөнгийн тооцог гаргаж хуулийн хугацаанд дээд байгууллагад хүргүүлсэн байна | Эрсдлийн ерөнхий үнэлгээг хийлгэж 7 дугаар сарын 1-ны дотор Онцгой байдлын газраас хянуулахаар ажиллаж байна.<br><br>**Хүрсэн түвшин: 100%** | 100 |
| 3.1.4 | Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд<br>Бүх нийтээр мод тарих ажилд идэвхитэй оролцож албан хаагч тус бүр 10 -аас доошгүй, байгууллага тус бүр 50-аас доошгүй мод бутыг тарьж, арчилж ургуулах, ургуулах боломжгүй | | Шинээр тарьсан мод<br><br>Нөхөн сэргээлтээр тарьсан мод<br><br>Модны ургалтын хувь | -шинээр тарьсан мод 56<br>-нөхөн сэргээлт 12<br>-ургалтын хувь 90%<br>-8100 мкв | Нөхөн сэргээлт хийх газарт тогтмол услалт цэвэрлэгээг хийсэн байна<br>Шинээр 20 модыг суулгасан байна. | Сум дундын ойн ангиас хариуцуулсан талбайн модыг хуваарийн дагуу 3 удаа усаллаа. Мөн модны талбайн хог, хаягддлыг 3 удаа цэвэрлэн хашаа, хайсийг засварлан янзлах ажлыг зохион байгуулсан.<br>2024 оны 5 дугаар сарын байдлаар 60 модыг тарьж, ажилтан, албан хаагчдаас болон хамтын сангаас модны суулгац худалдан авахад 120000 төгрөгийг зарцуулсан.<br><br>**Хүрсэн түвшин: 100%** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тохиолдолд мод тарьж ургуулах, арчлах зардлыг хандивлах. /Ойн тухай хуулийн 31.1 дэх заалт/ | | Талбайн хэмжээ, га | | | | |
| 3.1.5 | Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үүссэн хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, ангилан ялгах | - | Дахиварт нийлүүлсэн хаяг хаягдлын хэмжээ | Газрын хог хаягдлыг гялгар уут, хуванцар, цаас шил лаазаар ангилан хэвшсэн байн.Байгууллагын хог хаягдлынг аймгийн Хот тохижуулах газартай гэрээлэн ажлын өдөр бүр хогны машинд ачиж, төвлөрсөн хогийн цэгт хаяж байна. Сар бүр байгуулллагын гадна 50 метр талбайн хог хаягдлыг цэвэрлэж байна. Хог хаягдлын төлбөр хураамжийг бүрэн төлсөн байна | Байгууллагын гаднах хог хаягдлыг ангилан хаях хогийн савны төсвийг гаргуулж худалдан авсан байна. | Байгууллагын гадна 50м талбайн хогийг жижүүрүүд өдөр бүр цэвэрлэж 14 хоногт 1 удаа Хоггүй сүмбэр пэйжид мэдээллэж ирсэн. Хот тохижуулахын газартай гэрээ байгуулан ангилан ялгасан хогийг төвлөрсөн хогийн цэгт хаяуулж байна. Хот тохижуулахын газарт өр төлбөргүй.<br>Байгууллагын гадна хог ангилах хогийн сав авахаар төсвийг дээд газарт уламжилсан. Энэ ондоо багтаж хогийн цэгтэй болно.<br>Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын гадна хог хаягдлыг ангилан ялгах стандартын хогийн сав хийлгэх төсвийг гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн 6 дугаар сарын төсвийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.<br><br>**Хүрсэн түвшин: 6 дугаар сард бүрэн шийдвэрлэгдэнэ.** | 100 |
| 3.1.6 | Нээлттэй аймаг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, шилжин ирж буй алба хаагчийг дэмжих | - | Зохион байгуулсан арга хэмжээ тоо Шинээр шилжиж ирсэн албан хаагчийн тоо | Нээлттэй Говьсүмбэр хөтөлбөрийн хүрээнд Говьсмүбэрт ажиллаж байгаа боловч өөр аймагт харьяалалтай ААНБ-иргэдийг орон нутагт шилжин ирэхийг уриалан ажиллаж байна. | Нийгмийн даатгалын газарт сул ажлын байрыг huduu.mn нээлттэй Говьсүмбэр вэб сайтуудад түгээж ажилласан байна.<br>Ажлын байр сонирхсон иргэдтэй хамтран ажилласан байна. | Газрын Магадлагч эмчийн сул орон тоон дээр Улаанбаатар хотоос манай аймагт шилжин ажиллах хүсэлтийг 1 албан хаагчид санал болгосон. Хариу ирүүлээгүй байна. Зөвшөөрсөн хариу ирсэн тохиолдолд орон сууцны зээлд хамруулахаар банкуудад санал тавихаар төлөвлөөд байна.<br>Байгууллагын хэмжээнд хөдөө, орон нутгаас ажиллахаар ирж байгаа албан хаагч байхгүй байна.<br><br>**Хүрсэн түвшин: Одоогоор шилжин ирж ажиллах хүсэлт ирүүлсэн албан хаагч гараагүй байна.** | 100 |
| 3.1.7 | "Нэг өрх 1 ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлэх - | | Хөтөлбөрийр хэрэгжилт Хамрагдсан өрхийн тоо Хөтөлбөрийн хүрээнд ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | Байгууллагын зүгээс Шивээ-Овоо ХК-д ажилд оруулах санал хүргүүлсэн боловч мэргэжил таараагүй улмаас татгалзсан. Одоогоор Баяннексус ХХК-д төмөрийн дарханаар ажиллаж байна. | Иргэн Б.Баярдорж эрт илрүүлэгт хамруулсан байх | Газрын хариуцаж авсан иргэн Б.Баярдорж нь ам бүл 3 хоёр хүүхдийн хамт амьдардаг. Нимгэн төмрийн мужаан мэргэжилтэй. Сарын орлого 1,000,000 төгрөгний орлоготой. Хүүхдийн мөнгө, тэжээгчээ алдсаны тэжээгчээ алдсаны тэтгэмж авч амьддардаг. Газрын зүгээс Шивээ-Овоо уурхайд ажилд оруулах саналыг хүргүүлсэн боловч мэргэжил таараагүйн улмаас татгалзсан. Одоогоор Баяннексус төмрийн үйлдвэрт төмрийн дарханаар ажиллаж байна.<br>2024 оны 4 дүгээр сард эрүүл мэндийн үзлэгт хамруулах хүсэлтийг тавьсан боловч иргэн өөрөө татгалзсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Баярдоржийг Баяннексус ХХК цаашид тогтвор суурьшилтай ажиллуулах талаар компаний Говьсүмбэр аймаг дахь төлөөлөгчид хүсэлтийг хүргүүлсэн. | |
| 3.1.8 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлиг, Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны А/215 дугаар захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд Угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтанд албан хаагчдаа хамруулж угийн бичиг хөтлүүлсэн байна | | Угийн бичгийн сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо<br><br>Хамрагдалтын хувь<br><br>Угийн бичиг хөтөлж байгаа албан хаагчдын тоо | -14<br>-20%<br>-3 | -14<br>-40%<br>-6 | 17<br>100<br>6<br><br>Газрын 13 албан хаагчдад Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтанд 2 удаа хамрагдаж 4 албан хаагч угийн бичиг хөтлөж хэвшсэн, 2 албан хаагч угийн бичиг хөтлөх сургалтаас хойш угийн бичгийг хөтлөн эхэлсэн байна.<br><br>**Хүрсэн түвшин: 100%** | 100 |
| 3.1.9 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хэлтсийн хөдөлмөрийн дотоод журамд жендерийн тэгш байдлыг хангах 5 заалтыг оруулж хэрэгжүүлэн ажилласан байна. | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн танилцуулга сургалтыг зохион байгуулах хүсэлтийг аймгийн хүний эрхийн үндэсний комисст санал хүргүүлсэн байна. | Байгууллагын дотоод сургалтаар жендерийн сургалтыг 9 сард авахаар төлөвлөсөн байна. | |
| 3.1.10 | Төрийн болон төрийн өмчит байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд ашиглаж байгаа үйлдлийн систем, программ хангамжийг зөвшөөрөгдсөн албан ёсны эх үүсвэрээс авах, хорторй кодоос хамгаалах программ хангамж ашиглах | - | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн төслийн багаас хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн төслийн багаас зохион байгуулсан ажилд оролцоно. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “core”системээр хөтлөх гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс системийн хэмжээнд нэвтэрч байгаа “core”системд нягтлан бодох бүртгэлийн анхан шатны ажлуудыг ээлж дараалалтай хэрэгжүүлэн ажиллаж байна. Манай аймгийн хэмжээнд хүндрэл асуудал тулгарсан зүйлгүй. Хагас жилийн нийгмийн даатгалын сангийн тайланг энэ системээр гаргахаар зорин ажиллаж байна. Энэ систем бүрэн хэрэгжиж эхэлснээр нягтлан бодох бүртгэл мөн даатгалын үйлчилгээ бүрэн цахимжих боломж бүрдэнэ.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээлэл тооцооны төвөөс аймаг, дүүргийн нэгдсэн мэдээллийн санг эрсдэлээс урьдчилан сэргийлэх хамгаалах нөөцлөх асуудлуудыг бүрэн хариуцан шаардлагатай үед удирдлагаар хангаж ажилладаг болно.<br>**Хүрсэн түвшин: 100%** | 100 |
| 3.1.11 | Төрийн байгууллагын | - | Монгол бичгийн | -95% | Албан хаагч нарт | Газрын хэвлэмэл хуудасны эх загвар, гадна болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | алба хаагчдыг Монгол бичгийн сургалтанд хамруулж, хуучин монгол бичгээр унших, бичих чадварын сайжруулж, албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулж эхлэнэ. | | сургалтад албан хаагчдаа хамруулаcа байдал, хувь<br>Албан хэрэг хөтлөлтөд Монгол бичгийг нэвтрүүлсэн байдал, хувь | -90%<br>-50% | богино хэмжээний монгол бичгийн сургалтыг зохон байгуулсан байх.<br>Албан хэрэг хөтлөлтөнд монгол бичгийг нэвтрүүлсэн байх | өрөө тасалгааны хаягийг Үндэсний Монгол бичгээр хэвлүүлэн үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлсэн. Газрын алба хаагч хүмүүн бичиг сониний тогтмол захиалан уншиж өөрийгөө хөгжүүлдэг. Нийт албан хаагчдын 13 ажилтан буюу 100% нь Үндэсний Монгол бичгийн мэдлэг дунд болон дундаас дээш шатны мэдлэгтэй болсон. Аймгийн Насан туршийн боловсролын газрын сургагч Хонгорзулаас Цахим Монгол бичиг хичээлийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд ажлын 5 өдөр 2 цагаар хичээллүүлэхээр зохион байгуулан нийт албан хаагчдыг хамруулж байна<br>**Хүрсэн түвшин: 100%** | 100 |
| 3.1.12 | Монгол бичгийг иргэдэд сурталчлан түгээн дэлгэрүүлнэ. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | - | Шинээр хэрэгжиж байгаа нийгмийн даатгалын багц хуулийн богино танилцуулгыг монгол бичгээр хөрвүүлэн 81 иргэдэд тарааж ажилласан.<br>**Хүрсэн түвшин: 100%** | 100 |
| 3.1.13 | Төрийн үйл ажиллагааны шуурхай байдлыг хангаж, дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах. | - | ERP системийг нэвтрүүлэлтийн хувь<br>Албан бичиг хэргийг цахимжуулалтын хувь | 15<br>95% | 17<br>100% | ERP системийг ашиглаж байгууллагын бүтэц, хүний нөөцийн мэдээллийг бүртгэн оруулж байна.<br>Газрын удирдах болон гүйцэтгэх болон удирдах албан хаагчдын бүртгэлийг хийж харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн.<br>ERP системийн эрхийг үүсгүүлэн нийт 9 албан хаагч албан бичиг баримтыг цахим хэлбэрээр солилцож хэвшсэн.<br>ERP системээр ирсэн бичиг 79.<br>Явуулсан бичиг 36.<br>**Хүрсэн түвшин: 100%** | 100 |
| 3.1.14 | “Мэдээллийн ил тод байдлыг хангах төрийн үйлчилгээг цахимжуулах” арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | - | Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээ цахимжиж иргэд мэдээллээр хангагдсан байна. | Иргэд/даатгуулагч-д НДСангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тодорхойлолт<br>-НДШ төлөлтийн тодорхойлолт<br>-НДШ-н 50 хувийн буцаан олголт авах,дансны дугаар холбох<br>-Ажилгүйдлийн тэтгэмж авах цахим хүсэлт<br>-Жирэмсэн амаржсны тэтгэмэ авах хүсэлт<br>-ХЧТА авах хүсэлт<br>-СДД гэрээ байгуулах<br>-АО НДШ лавлагаа авах | Нийгмийн даатгалын 29 үйлчилгээ бүгд цахимжсан байна. | 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс нийгмийн даатгалын байгууллага системийн хэмжээнд 2005 оноос хойш ажиллаж байсан системийг шинэчлэж нэгдсэн “Core” системд шилжсэн. Өнөөдрийн байдлаар 29 үйлчилгээг цахимаар иргэдэд хүрч байна. Бусад үйчилгээнүүд шат дараалалтай цахимд шилжих боломжтой болсон.<br>**Хүрсэн түвшин: 100%** | 100 |
| 3.1.15 | Чанарын менежментийн | | Чанарын | Байгууллагын гадна | Чанарын | | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтолцоог нэвтрүүлж, бүтээмж, үр дүн, байгууллагын соёлыг дээшлүүлэх. | | менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн байдал<br><br>Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүн | дотор стандарын дагуу хийлгэх төсөв шийдүүлэхээр дээд газарт санал хүргүүлсэн. | менежментийн стандартын дагуу газрын гадна хаягжилтийг шинэчлэх ажлыг зохион байгуулсан байна. | Чанарын менежментийн тогтолцооны хүрээнд байгууллагын гадна болон дотор хаягийг /Монгол бичиг, крилл бичгийг хослуулан, англи хэлээр/ стандартын дагуу хийлгэж байршуулсан.<br><br>Ажилтан алба хаагчдыг чадавхжуулах ажлын хүрээнд 2024 оны 09 дүгээр сард Чанарын менежментийн тогтолцооны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>2025 онд Чанарын менежментийн тогтолцооны санхүүжилтийг төсөвт батлуулахаар саналыг оруулсан.<br><br>**Хүрсэн түвшин: 50%** | |
| *“Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.2.1 | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтйиг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлттэй ажиллах. | - | Зөрчилгүй дүгнэощлт авах, зөвлөмж, акт, албан шаарлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | А. Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланг аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан байна.<br>Б. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлнэ. | А. Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланг аудитаар зөрчилгүй дүгнэлт авах<br>Б. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100 хувь биелүүлсэн байна. | 2023 оны Байгуулллагын үйл ажиллагааны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр зөрчилгүй дүгнэлт авсан.<br>Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр бусад өр авлагын тодорхой хязгаарлалттай дүгнэлт авсан. Энэ нь нийгмийн даатгалын байгууллагын ахлах нягтлан бодогчийн сул орон тоо нөхөгдөөгүйн улмаас гарсан зөрчил юм. Аудитын дүгнэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газарт хүргүүлж ажилласан.<br>Хязгаарлагдсан дүгнэлтийн дагуу ажил сайжруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br><br>**Хүрсэн түвшин: Аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөр гаргаж хүргүүлнэ.** | 100 |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| *“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1.1. | Аймгийн удирдах байгууллагаас Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил | 500,0 | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлсэн эсэх | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, аймгаас өгсөн үүрэг даалгаврын | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, аймгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухай бүрт хугацаанд нь хүргүүлж ажиллаж байна.<br>Аймгийн удирдах ажилтаны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт 31,3% байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний хэрэгжилт, тайлан дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх | | | биелэлтийг цаг тухай бүрт хугацаанд нь хүргүүлж ажиллаж байна. | | | |
| 4.1.2. | Төрийн албан хаагчийг томилохдоо "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын зохицуулалтын дагуу зохист хэлбэрүүдийг ашиглан хууль зөрчихгүй ажиллах | 1000,0 | Нөхөгдөөгүй ажлын байрны зарыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлнэ | Зарлуулсан 5 ажлын байрнаас 1 орон too нөхөгдсөн | Зарлуулсан 4 ажлын байрнаас эхний хагас жилд 2 ажлын байрыг нөхсөн байна | Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлд сул орон тооны захиалгыг 5 удаа хүргүүлэн ажиллаж байна.<br>Байгууллагын "Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын газар"-ын цахим хуудсанд сул орон тооны зарыг байршуулсан.<br>Магадлагч эмч, Санхүү бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогч, Сайн дур, тэтгэмжийн байцаагч, Сургалт сурталчилгаа, сүлжээний инженер, Хүний нөөц, бичиг хэрэг дотоод асуудал хариуцсан ажилтан нийт 5 орон тоо нөхөгдөөгүй ажиллаж байна. Нөхөгдөөгүй ажлын байрыг тогтмол зарлуулан ажиллаж байна. | 100 |
| 4.1.3. | Албан ажлаар гадаад улсруу явахдаа аймгийн Засаг даргад мэдэгдэж зөвшөөрөл болон зөвлөмж, чиглэл авч байх, 7 хоногт багтаан бичмэл байдлаар тайлан ирүүлэх | 500,0 | Гадаад улсад зорчихдоо Аймгийн Засаг даргад мэдэгдэж, зөвшөөрөл авсан байх | Гадаад улсад зорчсон тохиолдол гараагүй. | Гадаад улсад албан томилолтоор ажиллах болсон тохиолдолд аймгийн Засаг даргаас зөвшөөрөл авсан байна | Газрын хэмжээнд 2024 оны 05 дугаар сарын байдлаар гадаад улсад албан ажлаар ажилласан тохиолдол гараагүй байна. | 100 |
| 4.1.4. | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | 500,0 | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 100 %-тай хэрэгжсэн байна. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчдаас гаргасан гомдол, хүсэлт, санал, өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэн хариуг хүргүүлсэн байна. | Эхний хагас жилийн байдлаар ERP систем болон ХУР-ДАН системийн оператор, 11-11 лавлах төвд гаргасан гомдол мэдээлэл ирээгүй.<br>Нийгмийн даатгалын хэлтэст 2024 оны хагас жилийн байдлаар нийт 16 өргөдөл, гомдол, санал, лавлагаа авах хүсэлт 38-ыг хүлээн авсан бөгөөд шийдвэрлэлт 100 хувьтай байна. Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд түргэн, шуурхай шийдвэрлэхэд анхааран ажилласан.<br><br>**Хүрсэн түвшин:100%** | 100 |
| 4.1.5. | Говьсүмбэр аймаг байгуулагдсаны 30 жилийн ой, "Боржигин наадам"-ыг тохиолдуулан байгууллага бүр тохижилт бүтээн байгуулалтын 1-2 ажил | 1000,0 | Аймгийн 30 жилийн тэгш тохиож байгаатай холбоотой байгууллагын гадна болон дотор орчиныг | Байцаагч ажилтнуудын өмнө сэтгэл ханамжийн судалгааг QR хэлбэрт оруулж байршуулсан. Ингэснээр иргэд ойлгомжтой байдлаар үйлчилгээний чанарт сэтгэл ханамжийн | Газрын үйлчилгээний заал, жижүүрийн хэсгийг тохижуулах, өнгө үзэмжийг сайжруулах, байгууллагын | Аймгийн 30 жилийн ойн арга хэмжээний хүрээнд байгууллагын гадна болон доторх тохижилтын ажлыг хийхээр дээд газарт төсвийн саналыг гаргаж хүргүүлсэн. 6 дугаар сард төсөв шийдэгдэх чиглэлийг ирүүлсэн тул тухайн үед тохижилтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санаачлан зохион байгуулж, байгууллагын гадна, дотоод өнгө үзэмжийг сайжруулах /нийтийн эзэмшлийн зам талбайг тохижуулах/ | | сайжруулж, бүтээлж ажлыг зохион байгуулах | судалгааг өгөх боломж бүрдсэн. | гадаад орчныг сайжруулж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ. Хийсэн ажлын тайланг Аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн байна. Баянтал суманд Нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх орон тооны бус төлөөлөгч ажиллуулсан байна. | | |
| 4.1.6. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах | | Оны эхэнд Авлигатай тэмцэх төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх | Авлигатай тэмцэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд бүрэн хэрэгжсэн байна | Авлигатай тэмцэх төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 20-ны дотор гаргаж батлуулсан байна. Төлөвлөгөөнд тусгагдсан 1 сургалтыг зохион байгуулсан байна | Авлига, Зөрчлийн тухай хууль сэдвээр 1 удаагийн сургалтыг нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тамгын газраас цахимаар авлигаас урьдчилан сэргийлэх цахим сургалтад нийт 10 албан хаагч хамрагдсан. 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө төрийн захиргааны 4 албан хаагч ХАСХОМ-ийг гаргаж хуулийн хугацаанд тайлагнасан. Албан тушаал өөрчлөгдөн томилогдсон төрийн захиргааны 2 албан хаагчийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн зөвшөөрлийг авч томилгоог хийсэн.<br><br>**Хүрсэн түвшин-100%** | 100 |
| 4.1.7. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллах | | Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлаар судалгаа хийж тусламж үзүүлэх, бүртгэлжүүлэх | 1,2 дугаар улиралд давхардсан тоогоор 13 ажилтан албан хаагч нарт 7 сая төгрөгийн урамшуулал олгосон | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2024 оны ажиллах төлөвлөгөөг гарган батлуулсан байна. | Ажилтан албан хаагчдын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор батлагдсан төсвийн хүрээнд газрын 1 дүгээр давхарын үйлчилгээний заалыг тохижуулан ажилласан.<br>Байгууллагын оны батлагдсан төсвийн хүрээнд ажилтнуудын нийгмийн баталгаа нангах хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газарт байгууллагын гадна орчныг тохижуулах төсвийн саналыг боловсруулан хүргүүлэн ажилласан.<br><br>**Хүрсэн түвшин 100%** | 100 |
| *“Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагаа хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны | 950,0 мян | Хүний нөөцийг чадавхижуулах | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур | Нийгмийн даатгалын | Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлөөс аймгийн нийт төрийн албан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.1. | мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | төгрөг | чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | чадварыг дээшлүүлэх 12 удаагийн сургалтад 15 албан хаагчийг хамруулсан. | ерөнхий газартай хамтран нийгмийн даатгалын шинэ програм болон 2024 онд хэрэгжиж байгаа хуулийн хэрэгжилтийн талаар сургалт мэдээллийг 2 удаа зохион байгуулсан байна. Мөн шинээр орсон албан хаагч нарт тухай бүр шинэ ажилтны сургалтыг явуулсан байна. | хаагчдад зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 цахим сургалт газрын нийт албан хаагчид хамрагдаж байна.<br>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албаны шинэтгэл, Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад газрын төрийн захиргааны 5 албан хаагч бүрэн хамрагдсан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газраас цахимаар зохион байгуулсан 4 удаагийн ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх сургалтанд нийт албан хаагчид хамрагдсан.<br><br>**Хүрсэн түвшин 100%** | |
| 4.2.2. | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах; | 500,0 | - Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 40 удаагийн сургалтад 1100 иргэд, даатгуулагчийг хамруулсан. | Эхний хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын хуулийн шинэчлэлийн талаар нээлттэй өдөрлөгүүд, сумдын иргэдийн нийтийн хуралд оролцон 20 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан 500 иргэнийг хамруулсан байна. | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр 4 дүгээр багийн өдөрлөг, хуулийн байгууллагуудын Про-Боно өдөрлөг, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын өдөрлөгүүдэд оролцож 110 иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжын талаар мэдээлэл хүргэж ажилласан байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэд, малчдад чиглэсэн сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулж 200 иргэн хамруулсан.<br><br>**Хүрсэн түвшин 100%** | 100 |
| 4.2.3. | Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | 2000,0 | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулахаар орон нутагт зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл<br>- Нийгмийн | Аймаг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийт сурталчилгаа явуулсан тоо 5,<br>-нийгмийн сүлжээгээр явуулсан сурталчилгааны тоо 25<br>Хамрагдсан хүний тоо 905 | Сүмбэрийн мэдээ 2 удаа, Говьсүмбэр TV 2 удаа, олон нийтийн сүлжээгээр өдөр бүр мэдээллийг тогтмол шинэчлэн оруулсан байна. | Говьсүмбэр телевизтэй хамтран газрын үйл ажиллагааны танилцуулга, 2 удаагийн нэвтрүүлгийг 4 удаагийн давтамжтайгаар цацаж ажилласан.<br>Нийгмийн сүлжээгээр 17 төрлийн постор, мэдээ мэдээллийг оруулж 51 удаагийн давтамжтайгаар түгээж ажиллаа. Хандалтын тоо 1700 гаруй байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулж байгаа шинэчилсэн хуулийн сурталчилгаа богино хэмжээний видео бичлэгийг Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын газартай хамтран цахим сүлжээнд түгээн ажилласан байна.<br>Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сүлжээний хуудас (фэйсбүүк)-нд мэдээлэл байршуулсан тоо, хандалтын тоо | | | богино хэмжээний контент бэлтгэж аймгийн хууль зүйн хэлтсийн контент оролцлоо.<br><br>**Хүрсэн түвшин 100%** | |
| *“Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх”* **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | |
| 4.3.1. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлтэй хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | 500,0 | 1. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлтэй холбоотой хууль тогтоомжийн чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна<br>2. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд болон мэргэжлийн сумын өрхийн эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдэд ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна | Зохион байгуулсан сургалт 4, хамрагдсан хүний тоо 150, тайланг НДЕГ-ын ЭМЗ-д хүргүүлсэн байна<br><br>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдэд дээрх сэдвээр 2 удаагийн сургалт зохион байгуулах | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлтэй холбоотой хууль тогтоомжийн чиглэлээр сумын, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтгүүдэд 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна | 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Эрүүл мэндийн магадлалын зөвлөл болон шинэчлэгдэж зөвлөлийн дүрэмд өөрчлөлт орсонтой холбоотой зөвлөлийн гишүүдэд Хөдөлмөрийн чадварын алдалтын заалт, зөвлөлийн шинэчилэн найруулсан дүрмийн талаар сургалтыг цахимаар 2 удаа зөвлөлийн гишүүдэд зохион байгуулсан.<br><br>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд болон өрх сумын эмч нарт ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эмчийн ёс зүй, эмнэлгийн хуудас бичих журмын талаар сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдөр зохион байгуулахаар Улаанбаатар хотын Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн 2 гишүүн эмчээр ахлуулсан баг 2021-2023 оны хооронд тогтоогдсон иргэдийн эмнэлгийн үзлэг карт, оношилгоо, шинжилгээнд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. шалгалтад 138 өвчтөн хамрагдаж байна.<br><br>**Хүрсэн түвшин 100%** | 100 |
| *“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх”* **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.1 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, даатгуулагчийн мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хангах | | Тухайн онд идэвхтэй шимтгэл төлөгч даатгуулагч, Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд, регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн регистрийн дугаартай 100% нийцсэн байна. | Нийт даатгуулагч, ажил олгогч регистрийн дугаар, овог, эцэг эхийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн регистрийн дугаартай 100 нийцсэн байна. | Нийт даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн регистрийн дугаартай нийцсэн байна.<br>Ажил олгогчийн үндсэн мэдээлэл буюу ЭЗҮАСА, өмчийн болон хариуцлагын хэлбэр, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | Нийгмийн даатгалын системийг улсын хэмжээнд шинэчилж байгаатай холбоотой иргэд даатгуулагчдын алдаатай мэдээллийг засаж, улсын бүртгэлийн мэдээллээс татаж шинэ програмд хөрвүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн ажил олгогчийн алдаатай мэдээллийг засаж ажиллаа.<br><br>**Хүрсэн түвшин 100%** | 100 |
| | | | **НИЙТ ДҮН** | | | | 96 |

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О. БАЙГАЛЬСАЙХАН